

PLITONIT

МЭРГЭЖИЛТЭН БАЙХ АМАРХАН



Plitonit
Deutsche
Qualität

PLITONIT КП PRO төгсгөлийн хана таазанд зориулсан полимер суурь дээр үндэслэсэн шаваас



Энэхүү бүтээгдэхүүн нь бетон, гөлтгөнө, гөлтгөнө болон цементэн суурьтай шавардлага, гөлтгөнө картон хуудас, модон суурьтай хана, таазыг хуурай байранд тэгшлэх зориулалттай. Нарийн төвөгтэй суурин дээр (тосон будгаар будсан гадаргуу, хуучин хавтан) КП PRO шаваасыг тэгшлэх давхарга болгон хэрэглэх боломжтой. Шаваасыг гар аргаар болон машинаар хэрэглэхийг зөвлөдөг бөгөөд ханын цаас болон бүдгийн доорх гадаргууг тэгшлэхэд ашиглаж болно. Найрлагад байх тусгай гидрофобик (ус түлхэгч) полимер хэрэглэснээр шаваасны хөрсжүүлэгч болон ханын цаасны цавуунд тогтвортой чадварыг нэмэгдүүлсэн. Нэг удаа түрхэх давхаргын зузаан: тасралтгүй тэгшлэх бол 0.1-ээс 3 мм хүртэл; хэсэгчлэн тэгшлэх бол 0.1-ээс 5 мм хүртэл байна. Илүү жижиг хэмжээтэй дүүргэгч бодистой, хольцын нягт бүтэц нь төгс гөлгөр гадаргууг олж авах боломжийг олгодог.

Савлагаа — 20 кг, 3 кг

- 2 нэгд байх будаг болон хананы цаасны цавууны дор байх
- Уян хатан чанар өндөртэй, ажиллахад хялбар
- Төгс гөлгөр
- Төгс цагаан
- Зүлгэх үед бутардаггүй
- Ханын цаасны цавуунд тэсвэртэй
- Чимэглэлийн бүтэц бий болгоход ашиглаж болно
- Суурьтай наалдах чадвар 0,7 МПа-аас багагүй байна

Бүтээгдэхүүний зарцуулалт

Гадаргууг тэгшлэх үед: 1 мм зузаантай түрхэх үед 1,0-1,2 кг/м².

Гөлтгөнө картон хуудаснуудын залгаасыг дүүргэх үед: 0,1-0,2 кг/м².

Ажлын нөхцөл

Ажлын явц болон гүйцэтгэлээс хойших 3 хоногт агаарын температур, суурийн температур +5°C хэмээс +30°C хэмийн хооронд байх нь зохимжтой. Ажлын явцад зуурмагийн температур +10°C хэмээс +30°C хэм хүртэл байх нь зохимжтой. Шаваасыг түрхэж, гадаргуу дээр хатаж байх үед нэвт салхи, нарны шууд тусгалаас зайлсхийх хэрэгтэй.

Гадаргууг бэлтгэх

Шаваасны гадаргуу нь бат бэх байх шаардлагатай, ажил эхлэхээс өмнө гадаргууг тоос, шороо, тос, бүх төрлийн будаг болон цавуу, хуурах боломжтой элементүүдээс сайтар цэвэрлэх шаардлагатай. Өндөр ус шингээх чадвартай тааз, гадаргуугийн шаваас хийхийн өмнө суурийг ПЛИТОНИТ Грунт 1 хөрсжүүлэгчээр боловсруулна.

Хэрэв цутгах суурь нь 5 мм-ээс дээш өндрийн зөрөөтэй, нэвт нүхтэй бол өнгөлгөө шавардлагын тэгшлэгч ПЛИТОНИТ ашиглан (хэрэглэх зааврын дагуу) гадаргууг урьдчилан тэгшлэх шаардлагатай.

Зуурмагийн хольц бэлтгэх

Зуурмагийг бэлтгэхийн тулд энгийн ундны усыг ашиглана. Холих харьцаа: 1 кг хуурай шаваасны хольцод 0,34-0,38 литр ус шаардагдана. Хуурай хольцыг тасалгааны температурт урьдчилан хэмжсэн зохих хэмжээний ус уруу хийнэ, нэгэн төрлийн жигд болтол нь 2-3 минутын турш эргэлтийн хурд нь 600 эргэлт/мин-ээс ихгүй байх цахилгаан холигч эсвэл цахилгаан өрмийн тусламжтайгаар холино. Зуурмагийг ойролцоогоор 510 минут амраан дахин холино. Энэ үед зөвшөөрөгдсөн хамгийн дээд хэмжээний үлдсэн усыг нэмж хэрэглэж болно. Бэлэн болсон битүү хаалттай саван дахь зуурмагийн хольцыг хэрэглэх хугацаа 7 хоног хүртэл байна.

Ажлын дараалал

Зуурмагийн хольцыг хусуур ашиглан гараар эсвэл шаваас хийх станц машин ашиглан хийж болно. Шаваасыг хэд хэдэн давхаргаар түрхэхдээ өмнөх давхаргыг бүрэн хатсаны дараа дараах давхаргыг түрхэх хэрэгтэй. Хатах хугацаа нь давхаргын зузаан, суурийн шингээх чадвар, агааржуулалт, агаарын температураас хамаарна. Гөлтгөнө картон хуудсан залгаасны хооронд зуурмаг шаваас хийхдээ хавтангийн үе далд ортол ба шургийн толгойн нүхэнд бас хэрэглэнэ. Бэхжүүлэгч туузыг залгаасны төвөөс байрлуулж, залгаасны бүх уртын дагуу хусуураар сайтар дардаг. Дараа нь нэмэлт хэмжээний шаваасыг хэрэглэж, эцэст нь тэгшилнэ. Хатсаны дараа тэгш бус хэсгүүдийг зүлгүүрийн багажны тусламжтайгаар арилгана. Зүлгүүрийн цаасны санал болгож буй ширхгийн хэмжээ: P120-P180 — ханын цаасан доор, P240-P280 – бүдгийн доор. Ханын цаас наах эсвэл бүдгийн ажил хийхийн өмнө гадаргууг хөрсжүүлэгчээр боловсруулалт хийхийг зөвлөж байна.

Чимэглэл бүхий гадаргууг бий болгох

Чимэглэлийн давхаргыг хийхээс өмнө суурь нь тэгш, нүх, хагарал, хэлтэрсэн хэсэгтэй эсэхийг шалгаарай. Өнгөлгөөний шавардлага, гөлтгөнө картон, ховилтой гөлтгөнө хавтан гэх мэт, шингээгч гадаргууг 1: 3 харьцаагаар шингэлсэн "PLITONIT Грунт 1" хөрсжүүлэгчээр заавал боловсруулсан байна. Бусад PLITONIT хөрсжүүлэгч, эсвэл хуурай үлдэгдэлтэй хөрсжүүлэгчийг 8% -иас багагүй бэлэн хэлбэрээр ашиглах боломжтой. Хөрсжүүлэгчийг хатаасны дараа 2-3 мм-ийн давхаргатай шаваасыг өргөн хусуур ашиглан 15-20 минутын дотор боловсруулж болохуйц талбайд түрхэн бүтцийн бул, сойз, хусуур эсвэл ямар нэгэн тохиромжтой хэрэгслээр хүссэн бүтцийг гарган авна. Шаваас хатсаны дараа нь цаашдын зүлгүүр, хөрсжүүлэгч, будах боловсруулалтад бэлэн болно.

Төвөгтэй гадаргуу дээр тэгшлэх шаваасны давхаргыг хэрэглэх

Ажил эхлэхийн өмнө хуучин гоёл чимэглэлийн бүрээс нь суурьтай бат бөх наалдсан эсэхийг шалгах ёстой. Гялгар вааран хавтанг тэгшлэхийн өмнө Плитонит БетонКонтакт болон СуперКонтакт хөрсжүүлэгчээр боловсруулж, шилэн тор ашиглан шаваасыг 2 давхарга түрхэхийг зөвлөж байна.

Анхааруулга

Ажлын явцад зуурмагийн хольцыг үе үе хутгахыг зөвлөж, усаар нэмэлт шингэлэхийг хориглоно.

Дээр заагдсан хугацаа нь орчны температур (20±2)°C, агаарын харьцангуй чийгшил (60±10)%-д үйлчлэх бөгөөд бусад үед хугацаа хэлбэлзэж болно.

Материал нь усанд тэсвэргүй ба чийгшил ихтэй газар ашиглахад зориулагдаагүй. Суурийн хэт их чийг нь тэгшилсэн гадаргуугийн өнгөнд өөрчлөлт (шарлуулж) үүсгэж болно.

Гадаргуугийн хамгийн төвөгтэй хэсэгт залгаас газарт ажил гүйцэтгэхдээ тусгай бэхжүүлэгч торыг ашиглах хэрэгтэй. Гөлтгөнө картон хуудсыг суулгахын өмнө залгаас нь V хэлбэртэй байхын тулд налуу ирмэгийн арилгах шаардлагатай.

Зэвэрсэн багаж хэрэгсэл, бохир сав ашиглаж болохгүй.

Аюулгүй ажиллагаа

Хольц нь ОХУ-ын стандарт хэмжилзүйн газрын ГОСТ 12.1.007 стандартын дагуу аюулын 4-р (бага аюултай бодис) ангилалд хамаарна. Ажил гүйцэтгэхдээ бээлий, нүдний шил, амны хаалт хэрэглээрэй. Зуурмагийг арьс, нүдэнд хүрэхээс зайлсхийх. Нүдэнд хүргэсэн тохиолдолд нэн даруй их хэмжээний усаар зайлна. ХҮҮХДЭЭС ХОЛ БАЙЛГААРАЙ.

Тээвэрлэлт болон хадгалах нөхцөл

Хуурай хольцыг ачаа тээвэрлэх дүрмийн дагуу бүрхүүлтэй тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ. Хуурай хольцтой уутыг савлагааны аюулгүй байдал, чийгээс хамгаалсан хуурай өрөөнд хадгална. Үйлдвэрлэгчийн саванд хадгалах хугацаа: цаасан уутанд - 12 сар, полимер уутанд - үйлдвэрлэсэн өдрөөс хойш 24 сар байна.

Орц, найрлага

Полимер холбогч бодис, эрдэс дүүргэгч, өөрчлөгч нэмэлт бүтээгдэхүүнүүд.

Үйлдвэрлэгчийн баталгаа

Хэрэглэгч тээвэрлэх, хадгалах нөхцөл, энэхүү гарын авлагад заасан зааврыг дагаж мөрдсөн тохиолдолд хольц нь техникийн үзүүлэлтүүдийн шаардлагад нийцэж байгааг үйлдвэрлэгч баталгаажуулна. Үйлдвэрлэгч нь материалтай ажиллах технологийг дагаж мөрдөхгүй байх, түүнчлэн эдгээр зааварт заагаагүй зорилго, нөхцөлд ашиглах үед хариуцлага хүлээхгүй. ГОСТ 8.579-2001 стандартын дагуу цэвэр жингийн хазайлт байна. Бүтээгдэхүүнийг бүх төрлийн иргэний барилгад ашиглахыг зөвшөөрсөн (Аэфф <370 Бк/кг байх ОХУ-ын "Цацрагийн аюулгүй байдлын стандартууд" НРБ-99/2009, ариун цэврийн дүрэм, журам СанПиН 2.6.1.25.23-09 нийцсэн.

Техник үзүүлэлтүүд

Өнгө	цагаан
Нэг удаагийн түрхэх давхаргын зузаан: - үргэлжилсэн тэгшилгээ - хэсэгчилсэн тэгшилгээ	0,1-оос 3 мм хүртэл 0,1-оос 5 мм хүртэл
Дүүргэгчийн ширхэг	0,1-0,2 мм
1 мм-ийн зузаантай давхаргаар түрхэх үед зарцуулалт	1,0-1,2 кг/м ²
Хэрэглэх усны хэмжээ 1 кг хольцод 3 кг хольцод 20 кг хольцод	0,35-0,40 л 1,05-1,2 л 7,0-8,0 л
Түрхэх зуурмагийн хольцын амьдрах чадвар	30 мм-ээс багагүй
7 хоногийн дараа суурьтай наалдсан бат бэх чанар	0,7 МПа-аас багагүй

Ажлын температурын горим	+5°С-аас +30°С хүртэл
Бэлэн болсон битүү хаалттай саван дахь зуурмагийн хольцыг хэрэглэх хугацаа	7 хоногоос хэтрэхгүй
2-р үеийг түрхэх, зүлгүүрдэх будах боломжтой	6 цагийн дараа
Усанд тэсвэртэй	усанд тэсвэргүй
Байгалийн радионуклидын цацраг идэвх	370 Бк/кг ихгүй

20 кг ууттай бүтээгдэхүүний логистикийн мэдээлэл

Хувийн бар-код 4607013040274

Багц дахь уутны тоо – 48 ширхэг

3 кг ууттай бүтээгдэхүүний хувьд Логистикийн мэдээлэл

Хувийн бар-код 4607013045972

Бүлэг бар-код 14607013045979

1 хайрцагт агуулагдах уутны тоо – 4 ширхэг

Нэг багц дахь уутны тоо – 224 ширхэг